

Авилгатай тэмцэх үйл хэрэгт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үндэс нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа бөгөөд түүнийг Авилгатай тэмцэх газарт нэвтрүүлэх нь

Албан тушаал: ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Эрдэнэ-Очирын Болор-Эрдэнэ

Харилцах утас: 70113214, 99093962

Цахим хаяг: Magic_berd@yahoo.com

Хураангуй: Манай улсын хууль сахиулах албаны уламжлал, тогтсон хэв маягт гэмт хэрэгтнүүдээс хууль дээдлэгч иргэдийг хамгаалах явдал байсан. Үүний тулд хууль зөрчсөн хүнийг эрэн сурвалжилж, мөрдөн шалгах, байцаан шийтгэх ажиллагаа явуулж тэднийг яллах, шийтгэл оногдуулах хэт нэг талыг барьсан арга барилаар ажиллаж ирсэн. Өөрөөр хэлбэл хууль сахиулагчид хэтэрхий завгүй ажиллаж байсан ч гэмт хэргийн гаралт мэдэгдэхүйц буурсангүй, ужиг самуун асуудал өнөөдөр ч гэсэн шийдвэрлэгдээгүй байгаа нь бидний үйл ажиллагаа хэт явцуу, “reactive” буюу үйл явдалд хариу үзүүлэх хэлбэртэй байсан нь өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцэхгүй болжээ.

Түлхүүр үгс: Авилгатай тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо, олон нийтийн ажиллагаан дахь хууль сахиулагчдын оролцоо, эрх, ашиг сонирхол.

Авилгатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албанд тэдгээрийг зохицуулахад иргэдийн эрх тэгш оролцоог хангах, цаашид улам боловсронгуй болгон өрөгжүүлэхэд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг шууд нэвтрүүлэх нь зүйтэй.

Тиймээс хууль сахиулах ажиллагааны идэвхтэй буюу “proactive” хэлбэрт анхаарч асуудал руу гэхээсээ илүүтэй тухайн асуудлыг нөхцөлдүүлж буй шалтгаан руу чиглэсэн урьдчилан сэргийлэх ажилд анхаарч ажиллах шаардлагатай болжээ.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу Community-Oriented Policing нь орчин үеийн цагдаагийн байгууллагын ардчилсан зарчмыг хангах тулгуур хүчин зүйл болж гадаадын олон орнуудын хууль сахиулах үйл ажиллагаанд өргөнөөр нэвтэрч, үр дүнгээ өгч байгаа юм. Энэ ойлголтыг 19 дүгээр зуунд Английн Ерөнхий сайдын албан тушаалыг хашиж байсан Sir Robert Peel анх 1829 онд тодорхойлохдоо “the police are the public and the public are the police”¹ буюу “цагдаа бол олон нийт, олон нийт бол цагдаа юм” гэжээ.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдгийг бүрэн дүүрэн ойлгохын тулд энэ нь чухамдаа юу биш юм бэ гэдэгт хариулт өгөх нь илүү ойлгомжтой байж болох юм.

1. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдэг нь гэмт хэрэгтнүүдэд “зөөлөн” хандах тухай номлол биш;
2. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдэг нь дээрээсээ босоо удирдлагын тогтолцоо бүхий захирах, захирагдах ёс биш;
3. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдэг нь огт эрсдэлгүй ажиллагаа биш;
4. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдэг нь юмыг зөв голдиролд нь оруулахын тулд хэрэглэх түр зуурын арга, механизм биш;

¹ https://en.wikipedia.org/wiki/Robert_Peel#Police_reform

Хууль сахиулах байгууллагууд хүний нөөц, санхүү, техник технологийн хувьд хариуцсан чиглэл, нутаг дэвсгэртээ бүрэн хүрч үйлчлэх бололцоо хомс бөгөөд хууль тогтоомж нутаг дэвсгэрийг бүрэн хамарч хүн бүрт алагчлалгүй үйлчлэх шаардлага тавигддаг. Тиймээс хууль сахиулах байгууллага хууль сахиулах үүргээ хэлбэрэлтгүй гүйцэтгэх тулгын 3 чулуу (хууль тогтоомж, хууль сахиулах байгууллага болон олон нийтийн дэмжлэг)-ны нэг нь олон нийтийн дэмжлэг туслалцаа бөгөөд Үндсэн Хуулийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн²” гэсэн заалтыг амьдралд хэрэгжүүлэх үндсэн нөхцөл байх болно.

“Иргэний оролцоог хангахын тулд юуны өмнө тэднийг хариуцлагажуулах шаардлагатай, хариуцлагажуулахын тулд тэдэнд эрхийг нь өг³” гэж 2012 онд “Иргэдийн оролцоог дэмжих хөтөлбөр”-ийг танилцуулах үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч онцлон тэмдэглэсэн байна.

Авилга, ашиг сонирхолын зөрчилтэй тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах ажиллагаанд олон нийтийн оролцоог дараах хэлбэрээр хангаж болно. Үүнд:

1. Бодлого, төсөв боловсруулахад оролцох
2. Бодлого хэрэгжүүлэхэд оролцох
3. Үйл ажиллагааны төсөв, хэрэгжилтэнд хяналт тавих
4. Үнэлгээ өгөх, хариуцлага тооцох зэрэг болно.⁴

Иргэдийн оролцоог хангаж, ардчилсан зарчмаар ажиллахын тулд байгууллага өөртөө ил тод байдлыг хангасан байх шаардлагатай. Монгол Улсын Авилгатай тэмцэх газар хир нээлттэй байгууллага вэ? Хүмүүс хүссэн цагтаа энэ байгууллагын төрийн нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг авах боломж, нөхцөл хангалттай бүрдсэн үү? Хүссэн үедээ хүмүүс энэ байгууллагаар зочилж, алба хаагчид, албан тушаалтнуудтай уулзаж санал бодол, мэдээлэл солилцох энгийн тааламжтай уур амьсгал, нөхцөл бүрдсэн үү?

Авилгатай тэмцэх газар сар бүр 15-30 хүнийг байгууллагадаа урьж ирүүлэн, үйл ажиллагааныхаа талаар болон зорилгоо танилцуулж байгаа нь сайшаалтай.

Байгууллага зөвхөн нээлттэй байгаад зогсохгүй олон нийттэй харилцаа үүсгэх, тэднийг идэвхжүүлэх, өдөөх, сайн дураараа тухайн байгууллага дээр ирж мэдээлэл солилцох, сонирхох сэдлийг төрүүлэхүйц нөхцөл байдлыг өөрөөр хэлбэл олон нийт, тухайн байгууллагын ашиг сонирхол нэгдэх хүчин зүйл юу байж болох яаж хүмүүст ойлгуулах арга замаа тодорхойлсон нөхцөл бүрдүүлсэн байх шаардлагатай.

Дээрх асуултын хариултыг орчин үеийн цагдаагийн шинжлэх ухаанд *Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа* буюу Community-Oriented Policing хэмээн тодорхойлж хууль сахиулах үйл ажиллагааны нэгэн судлагдахуун, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги болгон авч үздэг⁵.

Гол үзэл санаа нь иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж улмаар хууль сахиулах ажиллагаанд тэдний оролцоог хөхиүлэн дэмжиж, цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэвтрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах явдал нь бүх нийтийн үйл хэрэг мөн гэдэг ойлголтыг нийгэмд түгээн дэлгэрүүлэхэд оршиж байна.

² Монгол Улсын Үндсэн Хуулийн 1 дүгээр зүйл

³ <http://www.news.mn/r/127658>

⁴ “Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ” Судалгааны тайлан 9 дүгээр тал, 2013, Улс төрийн боловсролын академи

⁵ Page 196, The Encyclopedia of Police Science, 3rd edition, 2007

Энэхүү, үйл ажиллагааны стратеги гэж хэлж болох бодлогын хэрэгжилтийг хангахад байгууллага дараах хүчин зүйлүүдийг анхаарч, тэдгээртэй холбоотой асуудлуудыг үйл ажиллагааны бүх түвшинд шийдвэрлэсэн байхыг эрмэлзэх шаардлагатай.

1. Танай алба хаагчид олон нийтийн зохион байгуулалттай үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна уу?, тийм биш тохиолдолд алба хаагчдыг тийнхүү үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэд олон нийтэд ойр ажиллах боломж нөхцлийг хангах. Энэ тохиолдолд алба хаагчийн оролцох оролцоо нь, тухайн асуудал тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байх албагүй бөгөөд иргэд, олон нийттэй ойлголцох, ойр дотно холбоо тогтоох зорилгыг чухалчлах нь зүйтэй.
2. Алба хаагчид иргэд, олон нийтэд өөрийн хийсэн болон хийж буй ажил, арга хэмжээний талаар тайлагнаж байна уу? Хуулиар төрийн нууцад хамааруулсан эсвэл бусдад задруулсан тохиолдолд хууль сахиулах ажиллагаа, олон нийтийн ашиг сонирхол, хүний эрх эрх чөлөөг хангахад сөргөөр нөлөөлж болзошгүйгээс бусад мэдээллийг хүмүүст хүртээмжтэй хүргэх талаар алба хаагчдад зөвлөмж, зааварчилгаа, ажлын чиглэл тогтмол өгөх нь зүйтэй,
3. Байгууллагын бодлого, стратеги, шийдвэрүүдэд олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзлэлийг тусгах, тайлагнах ямар механизм байгаа болон түүнийг хэрхэн засан сайжруулах талаар дүн шинжилгээг тогтмол хийх,
4. Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой нийгмийн гишүүдийн сэтгэл зүй, хүсэл эрмэлзлэлийг тодорхойлох судалгааг жил бүр хийхтэй холбоотой төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн байх гэх мэт.

Иргэдэд эрхийг нь өгч хариуцлагажуулахын тулд тэдэнтэй энгийн харилцаанд орж, эрх үүргийг нь ойлгуулах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл шууд эрх олгох нь зохимжгүй бөгөөд ийм хариуцлага, эрхээс хүн татгалзах магадлал эсвэл хүлээн авсан ч түүнийгээ эдлэхгүй, хэрэгжүүлэхгүй байх хандлага түгээмэл.

Тиймээс олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлд гадаадын улс, орнуудын цагдаагийн байгууллага ямар ажил, арга хэмжээг зохион байгуулж байгаа талаар зарим нэг туршлагыг судалж үзэхэд:

Тухайлбал, Австралийн Холбооны Цагдаагийн Газар нийгмийн тодорхой хэсэг бүлгийг цагдаагийн байгууллагад урьж ирүүлэн, хүлээн авалт зохион байгуулж, цагдаагийн байгууллагын үндсэн зорилт, үйл ажиллагааны одоогийн болон ирээдүйн чиг хандлагыг танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах явдлыг тогтмолжуулсан байна⁶.

Энэ арга хэмжээг тодорхой цаг хугацаанд, нийгмийн тодорхой гишүүдийг, тухайлбал оюутан, сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл тэтгэврийн насны хүмүүс гэх мэт хамруулж, байгууллага, алба хаагчидтайгаа танилцуулах аялал, хүлээн авалтаар дамжуулж сургалт, сурталчилгааг нэгэн зэрэг хийдэг байна.

Сурталчилгааг байгууллагад зочилж ирэгсдэд хийхээс гадна олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж тухайн арга хэмжээ, түүний хүлээгдэн буй үр дүнгийн талаар нийтэд сурталчлах явдал түгээмэл байна.

Шинэ Зеландын цагдаагийн газар олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд цагдаагийн дүүрэг бүр хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хүн амын дунд спортын арга хэмжээг өөрийн улсын хүүхэд залуучууд өргөнөөр сонирхдог спортын төрөл (тэндэхийн тохиолдолд Rugby, Netball болон Cricket сонирхогчид давамгайлдаг)-үүдээр зохион байгуулж цагдаагийн алба хаагчид хариуцсан нутаг

⁶ <https://www.afp.gov.au/>

дэвсгэрийнхээ иргэдтэй нийлж, баг болж цагдаагийн байгууллага, дүүрэг хоорондоо өрсөлддөг⁷.

Иргэдийн энэ мэт хууль сахиулах үйл ажиллагаатай шууд холбоогүй оролцоогоор дамжуулж олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөрсийг бий болгох бөгөөд үүнтэй холбоотойгоор хүмүүсийн цагдаагийн байгууллагад хандах боломжийг нэмэгдүүлэх, хялбарчлах (easy access) үүднээс олон нийтийн гудамж талбайд байрлах худалдаа үйлчилгээний төв, барилга байгууламжууд, банк, иргэний бүртгэл, лавлагаа олгох, дэлгүүр, ресторан зэрэг үйлчилгээ үзүүлдэг иргэний нийгмийн бусад байгууллагуудын дунд цагдаагийн кобан, өрөө тасалгааг байрлуулж үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг хангаж ажилладаг.

Олон нийтийн итгэлийг олж, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь байгууллагын үйл ажиллагааны үндсэн стратеги хэдий ч алба хаагчдын (удирдах болон гүйцэтгэх) хувь хүний харилцааны соёл, ёс зүй, авьяас билэг, сэтгэлгээтэй салшгүй холбоотой.

Жишээ нь, өдрийн эргүүлийн маршрутанд үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн 2 алба хаагч цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд хэсэг хүүхдүүд скейтбордоор тоглож байгаатай таарч, нэг алба хаагч тэдэн рүү дөхөж очоод нэг хүүхдээс нь “үүгээр хэрхэн нааддагийг чамд үзүүлэх үү?” гэжээ, хүүхэд ч зөвшөөрч түүнд скейтбордоо өгсөн. Хүүхдүүд эхэндээ дүрэмт хувцастай цагдаагийн ажилтан скейтбордоор тоглож байгаад нь илүү анхаарч байсан ч хэсэг хугацааны дараа түүний скейтборд эзэмших ур чадварыг гайхан биширч түүнтэй дотно танилцахыг хүссэн⁸.

Түүний энэ байдлыг харсан дарга нь ямар шаардлага тавих байсан бол? (Монголчуудын байр сууринаас)

А. Түүнийг хүүхдүүдтэй тоглож зугаацахын оронд ажилдаа анхаарч хууль зөрчигсдийг баривчлах, торгох ажлаа зохих ёсоор хийхийг шаардах?

Б. Түүнийг бусдын хүсэл сонирхлоор нь дамжуулж тэдэнтэй сайн харилцаа тогтоож олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаанд зохих хувь нэмэрээ оруулж байгааг нь магтан сайшаах?

Эндээс харахад бид сэтгэлгээний хувьсал хийх зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл хууль сахиулагчид хэн нэгийг хууль зөрчсөнийх нь төлөө торгох эсвэл хэн нэгэнтэй сайн харилцаа үүсгэх 2-ын аль нь бидний хууль сахиулах, аюулгүй нийгмийг цогцлоон бүтээх эрхэм зорилгод илүү нийцэх вэ гэдэг шалгуурыг тодорхойлох хэрэгтэй болжээ.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ байгууллага, алба хаагчдын ажлыг баривчилсан хүн, ял төлөвлөсөн хэрэг, торгосон мөнгөн дүн, хүлээн авсан дуудлага мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлт зэрэг шалгууруудаар үнэлэхээс илүүтэй, асуудлыг бүрэн хэмжээгээр нь харж, олон нийтэд үйлчлэх, аюулгүй нийгмийн төлөө яаж ажилласан, асуудлыг олон нийтийн эрх ашгийн үүднээс шийдвэрлэж чадсан эсэх зэрэг өргөн хүрээгээр дүгнэж, цогц шийдлийг (Complex solutions) олох шаардлагатай. Олон нийтийн хяналт, оролцоогүй гаргаж буй шийдвэр, явуулж буй үйл ажиллагаа авилга, ашиг сонирхлын зөрчлийг бий болгох эрсдэлтэй. Тиймээс АНУ-д цагдаагийн үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь тус улсын цагдаагийн нийт байгууллагуудын 75 орчим хувийг хамарсан өргөн далайцтай арга хэмжээ болжээ.

Тухайлбал, олон нийт-цагдаагийн хамтын уулзалтыг тогтмол зохион байгуулах, иргэдийн хөршийн хяналтын системийг сайн дураараа дэмжих үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэд асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд цагдаад туслах арга

⁷ <http://www.police.govt.nz/advice/personal-community/new-arrivals/english/communities>

⁸ Шинэ Зеланд улсад суралцаж байх үедээ миний бие цагдаагийн алба хаагчидтай 2010 оны 10 сарын 15-нд нийслэл Веллингтон хотын гудамжинд эргүүлд ажилласан туршлагаас.

зүй, ач холбогдлыг сурталчлан таниулах, нийгмийн тодорхой бүлэг, гишүүдтэй уулзалт семинар тогтмол зохион байгуулах, хүүхэд залуусыг дэмжих хөтөлбөр, хохирогчдод туслалцаа үзүүлэх хөтөлбөр, нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг дэмжих, байж болох сайн туршлагаудын талаар зөвлөмж боловсруулж сурталчлах, газар зүйн байрлалаар нь гэмт хэргийн гаралт, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, цагдаагийн байр, кобаны тоог нэмэгдүүлэх гэх мэт⁹.

“Олон нийт” гэж хэнийг ойлгох тухай асуудал гарч болзошгүй. Энэ нь нийгмийн бүхий л гишүүдийг хамааруулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд тодорхой хэсэг бүлэг хүмүүсийг энэ ойлголтонд хамааруулж ойлгох нь зөв эсэх талаар маргаан үүсэж болзошгүй.

Ийм маргаан Ирланд улсад үүсэж байсан бөгөөд цагдаагийн байгууллагад тогтсон практикт үндэслэн цагдаагийн албаны тайлбарлаж байгаагаар: Олон нийт буюу Community гэдэг нь нийгмийн тодорхой ашиг сонирхол бүхий бүлэг, үндэсний цөөнх, хүүхэд залуус, жуулчид, ижил хүйстэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тусгай халамж шаардсан хүмүүс (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настнуудыг хамааруулсан) эсвэл тэднийг төлөөллийг ойлгох бөгөөд тэдгээрийн ашиг сонирхол нийгмийн нийт массын ашиг сонирхолтой давхцаж байгаа бол тэднийг олон нийт гэж үзэж болно¹⁰ гэж тодорхойлжээ.

Эндээс олон нийтийн санаа бодол, үзэл баримтлалыг үндэсний хэмжээнд судалж, дүн шинжилгээ хийж байх шаардлагыг¹¹ харж болно. Энэ нь олон нийтийн төлөөлөл гэж өөрсдийгөө үзэж байгаа тодорхой бүлэг, бүлэглэлийн эрх ашгийг хамгаалсан (жишээ нь Хадгаламж зээлийн хоршооны хохирогчид), ашиг сонирхлын зөрчилтэй байдлаас урьдчилан сэргийлж чадах юм.

Дүгнэлт

Хүмүүсийг төрийн үйл ажиллагааны бүхий л хэлбэрт агуулгын хувьд татан оролцуулж, хөндлөнгийн хяналтыг олон нийтийн туслалцаатай хэрэгжүүлэх нь хууль сахиулах ажиллагаа, ялангуяа нийгмийн тэгш, шударга байдлын ирмэг дээр байгаа авилга, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал хүчин зүйл учраас авилгатай тэмцэх ажилд мөн чанараар нь нэвтрүүлэх нь зайлшгүй гэдэгтэй олон хүн санал нийлэх байх.

Төр, түүний байгууллага, алба хаагчдын аливаа бодлого, шийдвэрүүд нь нийгмийн бүхий л гишүүдийн эрх ашиг, сонирхлыг хангаж чадахгүй, ялангуяа хууль сахиулах байгууллага шийдвэрээ өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хуулийн дагуу гаргаж байлаа ч түүнийг хүмүүс таагүй хүлээн авч, эсэргүүцэх, эсэргүүцэхгүй байлаа ч гэсэн энэ зөв биш шийдвэр юм гэсэн бодолтой үлдэх магадлал өндөр. Түүнчлэн шийдвэрүүд нь хуулиас илүү албан тушаалтнуудын, тодорхой бүлэглэл, олигархуудын ашиг сонирхолд дулдуйдаж гарах эрсдэл авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх чиглэлд өндөр байх магадлалтай.

Шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах нь дээрх бүхий л эрсдлийг бууруулж, төрийн үйл ажиллагааны үндсэн зорилтыг биелүүлэх нөхцөл бөгөөд авилгатай тэмцэх ажилд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг нэвтрүүлэхдээ.

1. *Эргэх холбоо.* Байгууллагадаа сайн дураараа хандах хүмүүсийн тоог нэмэгдүүлэхийн тулд хүлээн авалт, уулзалт, мэтгэлцээн, сургалт сурталчилгааг нийгмийн тодорхой бүлгүүдэд чиглүүлэн хийх ажлыг тогтмолжуулах. Үүнд байгууллагын бодлого шийдвэрүүдэд тэдний саналыг

⁹ Page 444, Police Administration, 7th edition, Gary W.Cordner & Kathryn E.Scarborough.

¹⁰https://www.oireachtas.ie/parliament/media/housesoftheoireachtas/libraryresearch/spotlights/Spotlight_Community_Policing_Final_Draft_124340.pdf

¹¹ НҮБ-ын 2004 оны Веннийн конвенцийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

тусгаж эргэж тайлагнах механизм, арга барилыг сурталчилан таниулна. Түүнээс гадна мэдээлэл түгээх, солилцох байр, нэгжүүдийг бий болгож иргэдийн тус байгууллагад хандах боломжийг нэмэгдүүлэх.

2. *Тайлагнах, ил тод байдал.* Алба хаагчдын иргэд, олон нийтэд тайлагнах, тэдэнд мэдээллийг цензуртэй, хүртээмжтэй хүргэх явдлыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ боловсруулан, нийт алба хаагчдаар дагаж мөрдүүлэх. Тухайлбал, үйл ажиллагааны журам боловсруулж мөрдүүлж болно.
3. *Алба хаагчдын оролцоо, хандлага.* Алба хаагчдын олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоулах нөхцөл боломжийг бүрдүүлж тэдэнд сэтгэлгээний өөрчлөлт хийх хандлагыг төлөвшүүлэх.
4. *Судалгаа, дүн шинжилгээ.* Олон нийтийн авилга, ашиг сонирхлын зөрчилтэй хийх тэмцлийн талаарх санаа бодлыг тодорхойлох болон авилга, ашиг сонирхлын зөрчлийг дэвэргэж, түүнд нөлөөлж буй нийгмийн шууд ба шууд бус хүчин зүйлс, хууль тогтоомжийн үзэл санаа, хэрэгжилтийн талаар судалгаа, дүн шинжилгээг тогтмол хийх. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хяналтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх байгууллагын механизмын тогтсон хэв шинжид (үүнд хууль тогтоомжийн болон тогтсон хэв маяг, практикт) тогтмол үнэлэлт өгөх, түүнийг засан сайжруулах талаар олон нийтийг хамарсан нээлттэй хэлэлцүүлэг хийх.
5. *Хөрөнгө орлогын болон зарлагын мэдүүлэг.* Авилгатай тэмцэх газар нийтийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг олон нийтэд ил тод болгож байгаа нь сайшаалтай боловч цаашид тэдний зарлагыг ч мөн адил бүртгэж олон нийтэд мэдээллэх ажлыг эхлүүлж, хэвшүүлэх шаардлагатай.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхээс гадна алба хаагчдын сэтгэлгээнд хувьсал хийхэд дэмжлэг болох учиртай.

Ашигласан материал:

- Монгол Улсын Үндсэн Хууль, 1993 он.
- Авилгын эсрэг хууль, 2006 он.
- Авилгын эсрэг НҮБ-ын Веннийн конвенци, 2004 он.
- The Encyclopedia of Police Science, 3rd edition, Jack R.Greene, 2007.
- Police Administration, 7th edition, Gary W.Cordener, 2009
- Black's Law Dictionary, 1983, Abridged 5th edition, Joseph R.Nolan & M.JConnolly.
- https://en.wikipedia.org/wiki/Robert_Peel#Police_reform.
- <http://www.news.mn/r/127658>.
- <https://www.afp.gov.au/>.
- <http://www.police.govt.nz/advice/personal-community/newarrivals/english/communities>.
- https://www.oireachtas.ie/parliament/media/housesoftheoireachtas/libraryresearch/spotlights/Spotlight_Community_Policing_Final_Draft_124340.pdf.
- “Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ” Судалгааны тайлан, Улс төрийн боловсролын академи 2013 он.